

“ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ЖУРАМ”-ЫН ТӨСӨЛ

БҮЛЭГ НЭГ. ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүй Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдах төмөр замын барилга, байгууламжид Төмөр замын тээврийн тухай хуульд заасны дагуу барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, (цаашид “барилгын ажлын зөвшөөрөл” гэх) ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулахад Төмөр замын тээврийн тухай хуулийн 11.1.5, 23 дугаар зүйл болон энэ журмыг баримтална.

1.3. Энэхүү журмын нэр томъёог Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн нийтлэг дүрэм, журам, үндэсний стандартад заасан утгаар ойлгоно.

1.4. Энэ журмын зохицуулалтад хамаарахгүй төмөр замын бусад дагалдах дэд бүтцийн барилга байгууламж нь Барилгын тухай хууль болон Эрчим хүчний тухай хууль, Цахим хөгжлийн багц хуулийн батлагдсан дүрэм, журмаар зохицуулагдана.

1.5. Олон улсын гэрээнд тусгайлан заагаагүй тохиолдолд төмөр замын барилга байгууламжийг барих ажлын техник, технологийн Захиалагчийн хяналтыг хөндлөнгийн хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

Хоёр. Төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх

2.1. Захиалагч төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг дараахь байгууллага, албан тушаалтанд гаргана:

2.1.1. Төмөр замын суурь бүтцийн барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад;

2.1.2. Төмөр замын тээврийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан салбар төмөр зам барих барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад;

2.1.3. Төмөр замтай бусад төмөр зам, авто зам огтлолцуулах барилгын ажлын зөвшөөрлийг төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад;

2.2. Захиалагч нь төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтэд энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг хавсаргасан байна.

2.3. Зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

2.4. Эрх бүхий байгууллага төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг хянах явцад шаардлагатай бол холбогдох байгууллагаас тодруулга авч болно.

2.5. Энэ дүрмийн 2.4-д заасны дагуу тодруулга авсан тохиолдолд төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг хянан шийдвэрлэх хугацааг шинээр тоолно.

2.6. Суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрөл олгоход магадлагдсан зураг төслийг үндэслэн шийдвэрлэнэ.

2.7. Төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийг барилгын ажил гүйцэтгэх ажлын хэмжээ, ажлын технологи болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд заасан төлөвлөгөөний дагуу барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар олгоно.

Гурав. Төмөр замын барилга байгууламжийн ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох

3.1. Төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийг энэ дүрмийн 1 дүгээр хавсралтад заасан гэрчилгээгээр баталгаажуулан олгоно.

3.2. Төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг 2 хувь үйлдэж, захиалагчид 1 хувийг олгож, үлдсэн хувийг архивт хадгална.

3.3. Төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд энэ дүрмийн 2, 3 дугаар хавсралтад заасны дагуу хугацаа сунгалт болон нэмэлт, өөрчлөлтийг бүртгэнэ.

3.4. Захиалагч байгууллага ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа дуусхаас ажлын 10 хоногийн дотор төрийн захиргааны төв байгууллагад сунгах хүсэлтийг хүргүүлнэ.

3.5. Захиалагч барилгын ажлын явцад өөрчлөлт гарсан тохиолдолд Төмөр замын тээврийн тухай хууль болон төмөр замын багц журамд заасны дагуу зохих арга хэмжээг авч, зөвшөөрөл олгосон байгууллагад тухай бүрд нь мэдэгдэнэ:

3.5.1. Төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон;

3.5.2. Гүйцэтгэгч, захиалагч болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэх байгууллага өөрчлөгдсөн;

3.5.3. Гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;

3.5.4. Төмөр замын барилга байгууламжийн үндсэн хийц бүтээцэд өөрчлөлт оруулж, зураг төсөл өөрчлөгдсөн;

3.5.5. Дуусаагүй барилга байгууламжийг хамгаалалтын горимд оруулах болон уг хугацаа дуусгавар болсон.

3.6. Зөвшөөрөл олгосон байгууллага нь барилгын ажлын явцад өөрчлөлт орсон тохиолдол бүрд энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу өөрчлөлтийг бүртгэж, гэрчилгээнд хавсаргана.

3.7. Ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон өдрөөс 1 жилийн хугацаанд барилга угсралтын ажил эхлээгүй тохиолдолд тухайн зөвшөөрлийг хүчингүйд тооцно. Энэ тохиолдолд ажил эхлүүлэх зөвшөөрлийг дахин гаргаж шийдвэрлэнэ.

3.8. Төмөр замын барилгын ажил 6 сараас дээш хугацаагаар зогссон, салбарын хяналтын Улсын байцаагч, техник, технологийн захиалагчийн хяналтын санал, дүгнэлтийг үндэслэн барилга угсралтын ажлыг зогсоосон тохиолдолд ажил эхлүүлэх зөвшөөрлийн хүсэлтийг дахин гаргах бөгөөд энэ журмын 2 болон 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу өөрчлөлтийг бүртгэнэ.

3.9. Зөвшөөрөлтэй холбоотой тайланг тухай бүр гаргаж төмөр замын барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.10. Зөвшөөрлийг сунгуулах тухай хүсэлт ирүүлээгүй бол төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг сунгахгүй бөгөөд зөвшөөрлийн хугацаа дуусмагц гэрчилгээг хүчингүйд тооцно.

Дөрөв. Төмөр замын барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгохоос татгалзах

4.1. Зөвшөөрөл олгох байгууллага дараахь үндэслэлээр Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзана:

4.1.1. Баримт бичгийн бүрдэл дутуу, эсхүл хуурамчаар үйлдэж бүрдүүлсэн;

4.1.2. Баримт бичиг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага /захиалагч, техник, технологийн захиалагчийн хяналт, гүйцэтгэгч байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, зураг төсөлд магадлал хийгдээгүй, төлөвлөлтийн болон норматив баримт бичгийн шаардлагыг зөрчсөн/-д нийцээгүй.

4.2. Барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрийг бичгээр гаргаж, хүсэлт гаргагчид албан бичгээр хүргүүлнэ.

4.3. Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл зохих ёсоор олгогдоогүй барилга байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг хориглоно.

4.4. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт зааснаас бусад тохиолдолд төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгогдоогүй барилга байгууламжид зөвшөөрлийг нөхөж олгохыг хориглоно.

БҮЛЭГ ХОЁР. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ШИНЭЭР БАЙРЬЖ БАЙГУУЛСАН, ШИНЭЧЛЭН САЙЖРУУЛСАН СУУРЬ БҮТЦИЙГ БАЙНГИЙН АШИГЛАЛТАД ОРУУЛАХ

Тав. Шинээр барьж байгуулсан, шинэчлэн сайжруулсан төмөр замын тээврийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх

5.1. Захиалагч төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт гаргахын өмнө Төмөр замын тээврийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу бичиг баримт бүрдүүлж, Техникийн комиссын үзлэг хийлгэж, дүгнэлтэд заасан зөрчлийг арилгах арга хэмжээ авсан байна.

5.2. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийг дараах байгууллагад хүргүүлнэ:

5.2.1. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтээ төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад;

5.2.2. Бусад дэд бүтцийн барилга байгууламжийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмын дагуу тухайн чиглэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад;

5.2.3. Орон сууцны барилга, үйлдвэрлэлийн бус (нийгмийн) зориулалттай объектуудыг ашиглалтад хүлээн авахдаа Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын барилга байгууламжуудыг хүлээн авах, ашиглалтад оруулах журмыг удирдлага болгоно.

5.3. Захиалагч байгууллага нь төмөр замын барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах хүсэлт гаргахын өмнө энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан бичиг баримтын бүрдлийг хангасан байна.

5.4. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийг төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

5.5. Батлагдсан зураг төсөл бүхий шинээр барьж байгуулсан, шинэчлэн сайжруулсан төмөр замын тээврийн барилга байгууламжийг энэ журмаар тогтоосон дэгээр гүйцэтгэгч байгууллагаас хүлээн авч байнгын ашиглалтанд оруулна.

Зургаа. Шинээр барьж байгуулсан, шинэчлэн сайжруулсан Төмөр замын тээврийн барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулах

6.1. Шинээр барьж байгуулсан, шинэчлэн сайжруулсан төмөр замын тээврийн барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авах ажлыг улсын комисс эсвэл захиалагч байгууллага нь төрийн байгууллагууд, орон нутгийн эрх баригчдын төлөөллийг оролцуулан гүйцэтгэнэ.

6.2. Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтэд хавсаргасан энэ журмын хавсралт 9-д заасан баримт бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангасан бол төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг байгуулна.

6.3. Төмөр замын тээврийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэлдэхүүнтэй томилно:

6.3.1. Төмөр замын суурь бүтцийн барилга байгууламж (шинээр барих, шинэчлэх)-ийг ашиглалтад оруулах Техникийн комиссыг энэ журмын 4 дүгээр хавсралтын 1-д заасан бүрэлдэхүүнтэй;

6.3.2. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 11.1.5, 23.5-д заасан төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссын бүрэлдэхүүнийг 4 дүгээр хавсралтын 2-т заасан бүрэлдэхүүнтэй;

6.3.3. Салбар төмөр зам барих, засварлах, өргөтгөх, объект байрлуулах ажлыг ашиглалтад оруулах Ажлын хэсгийг энэ журмын 4 дүгээр хавсралтын 3-т заасан бүрэлдэхүүнтэй;

6.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн шинээр барьж байгуулсан, шинэчлэн сайжруулсан төмөр замын тээврийн барилга байгууламжийг төмөр замын зэрэглэлээс үл хамааран ашиглалтад хүлээн авах ажлыг Улсын комисс гүйцэтгэнэ.

6.5. Төмөр замын тээврийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан салбар төмөр зам нь өртөө, зөрлөг болон дагалдах барилга байгууламжтай тохиолдолд төрийн захиргааны төв байгууллагын Техникийн болон Улсын комисс ажиллан хүлээн авна. Бусад тохиолдолд төмөр замын тээврийн объектыг барьж дуусгах, шинэчлэн сайжруулах ажлыг захиалагч гүйцэтгэнэ.

6.6. Төмөр замын тээврийн барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авахад Техникийн комиссын үзлэг шалгалтаар илэрсэн алдаа, доголдлыг бүрэн зассан байна.

6.7. Комиссын бүрэлдэхүүнийг томилсоноос хойш ажлын 5 хоногийн дотор ашиглалтад хүлээн авах төмөр замын төслийн талбайд очиж ажиллана.

6.8. Комиссын шийдвэрээр ажиллах хуваарийг тогтоож 3 хоногийн өмнө гишүүдэд байршил, хугацаа, тухайн барилга байгууламжтай холбоотой мэдээллээр хангасан байна. Комиссын нарийн бичгийн дарга, техник, технологийн хяналтын баг, гүйцэтгэгч нар хамтран зохион байгуулна.

6.9. Комиссын зардлыг гүйцэтгэгч байгууллага хариуцна.

6.10. Хүлээн авахдаа төмөр замын тээврийн барилга байгууламж нь Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн нийтлэг дүрэм, журам, үндэсний стандартууд, батлагдсан төсөлд нийцэж байгаа эсэх, түүнчлэн Монгол улсын "MNS6229:2010 1520 мм-ийн царигтай төмөр зам. Техникийн ерөнхий шаардлага" стандартын шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох шаардлагатай.

6.11. Төмөр замын тээврийн барилга байгууламжийг ашиглалтад авах тухай Комиссын дүгнэлт гарч актаар баталгаажуулснаар тухайн төмөр зам, замын байгууламжийг ашиглалтад оруулсанд тооцно.

6.12. Төмөр замын тээврийн барилга байгууламжийг ашиглалтад оруулсан огноо нь улсын комисс эсвэл захиалагч хүлээн авч гарын үсэг зурсан өдөр байна.

Долоо. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын чиг үүрэг

7.1. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1. Төмөр замын тээврийн тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандарт, зураг төсөл, техникийн баримт бичигт заасан шаардлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн шаардлагыг хангасан төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах;

7.1.2. Комисс нь мэргэжлийн чиглэл, ажил үүргийн дагуу ажилласан гишүүдийн санал, дүгнэлтийг үндэслэн, олонхийн саналаар эцсийн шийдвэрийг гаргах ба энэхүү шийдвэр нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм, тогтоомжид нийцэх;

7.1.3. Төмөр замын суурь бүтцийн дагалдах барилга байгууламж, түүнд суурилагдсан тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээний туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийсэн дүгнэлт, баталгаажуулалт, техникийн баримт бичгийн бүрдүүлэлт хийсэн байдлыг шалгах;

7.1.4. Салбарын хяналт хэрэгжүүлэх байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар төмөр замын барилгын ажлын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан эсэхийг дүгнэх;

7.1.5. Энэ журмын 6.5-д заасан Техникийн комиссын өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангасан эсэхэд хяналт тавих;

7.1.6. Монгол Улсын стандарт, норм, дүрэм, техникийн шаардлага, зураг төслийг ноцтойгоор зөрчсөн, чанаргүй хийсэн, техник технологийн захиалагчийн хяналт, Салбарын хяналтын байгууллагуудаас тавьсан шаардлага, Техникийн комиссын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд ашиглалтад хүлээн авахыг хойшлуулах, холбогдох байгууллагаар хөндлөнгийн дүгнэлт гаргуулах;

7.1.7. Төмөр замын тээврийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, стандарт, техникийн баримт бичгийн заалтыг зөрчсөн тохиолдолд техник технологийн захиалагчийн хяналт, гүйцэтгэгч, зураг төслийн байгууллагуудад хариуцлага тооцох, холбогдох тусгай зөвшөөрлийн эрхийг нь түдгэлзүүлэх, цуцлах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх;

7.1.8. Комисс нь шинээр баригдсан, шинэчлэн сайжруулсан төмөр зам нь галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан тохиолдолд бүрэн болон хэсэгчлэн ашиглалтад авах, хөдөлгөөн нээх дүгнэлт гаргаж болно;

7.2. Төмөр замын шинэ шугам, шинэчлэн сайжруулсан шугам, цахилгаанжуулсан төмөр замын хэсгүүд, дохиолол, төвлөрөлүүлэлт ба хориглолын төхөөрөмж байгууламж (SCB), шинэчлэн сайжруулсан зангилаа ба өртөө зөрлөг, үйлдвэр болон төмөр замын тээврийн үйлдвэрлэлийн зориулалттай бусад барилга

байгууламжийг тусад нь хэсэгчлэн (хэсэглэл, хоорондын зам, өртөөний болон зангилааны замууд, парк, цех болон бусад) ашиглалтанд хүлээн авч болно.

7.3. Үйлдвэрлэлийн болон нийгмийн зориулалттай төмөр замын тээврийн барилга байгууламж, тэдгээрийн инженерийн байгууламж, төхөөрөмж, түүний дотор суурин газруудаас 4 км-ээс дээш зайд ажиллах ээлжийн ажилтнуудын цогцолборыг барилга угсралт, зохих тоног төхөөрөмжүүдийг байрлуулан туршиж, шалган ажиллагаанд оруулж, тохижилтын ажил дууссаны дараа хүлээн авна.

7.4. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд барилга байгууламжийн хэвийн үйл ажиллагаатай холбоотой энэ журмийн 9 дүгээр хавсралтад заасанаас бусад баримт бичгийг нэмж тодруулж болно.

7.5. Комисс нь төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах эсэх хуралдаанаас хойш ажлын 21 хоногийн дотор дүгнэлт гарган баталгаажуулна.

Найм. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын ажиллах журам

8.1. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс (цаашид "Комисс" гэх) нь барилга байгууламжийг ашиглалтад оруулахтай холбоотой асуудлыг хуралдаанаар хэлэлцэж, дүгнэлт гаргана.

8.2. Комисс дүгнэлт гаргахын өмнө тухайн барилга байгууламжтай танилцан үзлэг хийж, зөрчил дутагдал илэрсэн бол түүнийг арилгуулахаар захиалагч, гүйцэтгэгчид үүрэг даалгавар өгнө.

8.3. Комиссын нарийн бичгийн дарга комиссын хуралдааны бэлтгэлийг хангах, гишүүдийн ирцийг бүрдүүлэх, хуралдаан зохион байгуулах, хуралдааны тэмдэглэл хөтөлж баталгаажуулах, дүгнэлт үйлдэх ажлыг хариуцах бөгөөд баримт бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангасан бол комисс ажиллуулах мэдэгдэлийг комиссын гишүүдэд тараана.

8.4. Комиссын хуралдааныг гишүүдийн 90 хувиас доошгүй ирцтэй зохион байгуулна. Комиссын хуралд хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцох боломжгүй гишүүн хурлаас 1 өдрийн өмнө комиссын нарийн бичгийн даргад мэдэгдэх ба тус гишүүн нь нөхөж ажиллах боломжгүй байна.

8.5. Комиссын үйл ажиллагаа нь дараах дарааллаар зохион байгуулах зарчим баримтална:

8.5.1. комиссын ажиллахаас өмнө комиссын гишүүдийг томилсон шийдвэр, комиссын ирцийг комиссын нарийн бичгийн дарга танилцуулж энэ дүрмийн 8.4-т заасан ирц хангагдсан эсэхийг оролцогчдод мэдээлнэ;

8.5.2. комиссын дарга комиссын гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй болохыг илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн хуудсыг бөглүүлж ашиг сонирхлоос сэргийлэх арга хэмжээ авна;

8.5.3. комиссын гишүүд төмөр замын барилга, байгууламжийн баримт бичиг, техникийн төлөв байдал, шаардлагатай тохиолдолд далд ажлыг ил гаргаж

үзэх, барилгын үйл ажиллагаанд оролцогчдоос нэмэлт мэдээлэл авах, барилга байгууламжтай танилцах;

8.5.4. комиссын гишүүд хариуцсан асуудал тус бүрээр хийж гүйцэтгэх шаардлагатай ажил, нэмэлт мэдээлэл зөвлөмж, саналаа өөрийн биеэр уншиж танилцуулах бөгөөд барилга байгууламжийг ашиглалтад оруулах боломжтой эсэх дүгнэлтээ тодорхой мэдэгдэх;

8.5.5. комиссын дарга комиссын гишүүдийн олонхын саналд үндэслэн хугацаатай үүрэг даалгавар өгч хурлын үйл ажиллагааг хаахаар зохион байгуулна.

8.6. Комисс ажилласаны дараа комиссын гишүүд өгсөн санал, үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж, биелэлт хангагдсан тохиолдолд энэ дүрмийн 7 дугаар хавсралтад заасан үүрэг даалгаврын биелэлтийн хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулна.

8.7. Комисс асуудлыг хэлэлцээд зөрчилтэй, эсхүл захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлтэд заасан шаардлага хангагдаагүй гэж дүгнэсэн бол төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзаж, захиалагчийн хүсэлтийг буцаана.

8.8. Захиалагч нь ашиглалтад оруулах комисс, техникийн комиссын шийдвэр, гишүүдийн үйл ажиллагааны талаарх гомдол, хууль бус үйлдлийг тухайн комиссыг байгуулсан эрх бүхий албан тушаалтан эсхүл холбогдох хууль хяналтын байгууллагад гаргаж болно.

8.9. Комиссын гишүүн батлагдсан зураг төсөл болон холбогдох хууль дүрэм, журам, норм дүрмийн шаардлагад нийцэхгүй үүрэг даалгавар өгсөн бол хариуцлагыг өөрөө хүлээнэ.

8.10. Энэ журамд заасныг зөрчсөн албан тушаалтан, байгууллага, хувь хүнд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

Ес. Комиссын дүгнэлт

9.1. Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 өдөрт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.

9.2. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн 7.5-д заасан хугацаанд багтаан дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

9.2.1. барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт;

9.2.2. энэ дүрмийн 7.1, 6.6-д заасан шаардлага хангаагүй, 9.1-д заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт.

9.3. Комисс нь төмөр замын суурь бүтцийн барилга байгууламж болон энэ журмын 2.3-т заасан шийдвэрээр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргахдаа техникийн комиссын акт, дүгнэлтийг үндэслэнэ.

9.4. Техникийн комиссоос төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулахаас татгалзсан дүгнэлт гаргасан, эсхүл техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй бол техникийн комиссыг дахин ажиллуулна.

9.5. Энэ дүрмийн 6.9-т заасны дагуу ашиглалтад оруулах комисс, техникийн комиссыг дахин ажиллахтай холбогдох зардлыг гүйцэтгэгч хариуцна.

9.6. Комиссын дарга барилга байгууламжийн ашиглалтад оруулах дүгнэлт гаргаж, баталгаажуулсан бол ажлын 10 өдөрт багтаан төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албан бичгээр мэдэгдэж, ашиглалтад оруулна.

9.7. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааны гэрчилгээ олгох эрх бүхий тухайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хандаж салбар төмөр зам, зарим барилга байгууламжид гэрчилгээ олгох үйл ажиллагааг Төмөр замын тээврийн тухай хуулийн 10.2.16.-д заасны дагуу хэрэгжүүлнэ.

Арав. Бүртгэл, мэдээлэл

10.1. Зөвшөөрөл олгосон байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд барилгын ажлын зөвшөөрөл олгосон, цуцалсан, хугацаа сунгасан барилгын ажлын зөвшөөрлийн бүртгэлийг хөтлөх чиглэлээр дараахь үүрэгтэй:

10.1.1. Улсын комиссын дүгнэлтэд Улсын хөрөнгө оруулалтаар шинээр барьж байгуулсан, шинэчлэн сайжруулсан төмөр замын тээврийн барилга байгууламжийг Улсын бүртгэл мэдээллийн санд бүртгүүлэх тухай тусгах;

10.1.2. Төмөр замын тээврийн барилга байгууламжийг барьж байгуулж дуусгах, шинэчлэн сайжруулах ажлыг хүлээн авч ашиглалтад оруулсан тухай мэдээллийг тогтоосон журмаар улсын статистикийн байгууллагад хүргүүлэх

10.2. Улсын комисс хүлээн авсны дараа гүйцэтгэгч байгууллага нь баримт бичгийн бүрдлийг Үндэсний төв архивын журмын дагуу бүрдүүлж Захиалагчид хүргүүлнэ. Захиалагч байгууллага нь баримт бичгийг Үндэсний төв архивт хүлээлгэн өгөх ба хувийг Зам, тээврийн хөгжлийн яам болон суурь бүтэц эзэмшигч байгууллагын архивт хадгална.

10.3. Ашиглалтад оруулсан төмөр замын барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичгийг архивт хүлээлгэн өгч, Төмөр замын тээврийн тухай хуулийн 10.2.14.-д заасны дагуу мэдээллийн нэгдсэн санд холбогдох мэдээллийг хүргүүлэх ажлыг захиалагч хариуцна.

10.4. Ашиглалтад оруулах комисс, техникийн комиссын дүгнэлтийг кадастрын цахим мэдээллийн санд оруулах зорилгоор шаардлагатай мэдээллийг аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх ажлыг захиалагч хариуцна.

.....

Төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх,
ашиглалтад оруулах журмын 1 дүгээр хавсралт

ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГЫН АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

20 ... оны ... сарын
..... -ны өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

1. Төмөр зам, замын байгууламж түүний туслах барилгуудын мэдээлэл:

Төмөр зам, замын байгууламж, объектын нэр:.....

Хүчин чадал, байршил, хэмжээ, үндсэн хийц бүтээц:

Хаяг: аймаг /нийслэл/,.....сум /дүүрэг/,
.....баг /хороо/,.....гудамж /хороолол/

Зургийн шифр:..... Магадлалын дугаар:

Зөвшөөрөл олгосон үе шатны ажлын нэр:.....

Зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:.....

2.Газар олгосон шийдвэрийн мэдээлэл:

Газар олгосон шийдвэрийн (захирамж): 20.... онысарын өдрийн.... дугаар

Байршил: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/,гудамж /хороолол/

3.Гүйцэтгэгч байгууллагын талаарх мэдээлэл:

Байгууллагын оноосон нэр:.....

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

Байгууллагын тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар:.....

Хаяг:аймаг /нийслэл/,.....сум /дүүрэг/,
.....баг /хороо/,.....гудамж /хороолол/

Холбоо барих: цахим хаяг, утасны дугаар

4.Захиалагч байгууллагын талаарх мэдээлэл:

Байгууллагын оноосон нэр:

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/, гудамж /хороолол/

Холбоо барих:..... цахим хаяг, утасны дугаар

5.Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг эрхлэгч байгууллагын талаарх мэдээлэл:

Байгууллагын оноосон нэр:

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

Байгууллагын тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар:.....

Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/, гудамж /хороолол/
Холбоо барих:..... цахим хаяг, утасны дугаар

6. Зураг төсөл зохиогч байгууллагын талаарх мэдээлэл:

Байгууллагын оноосон нэр:.....
Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:
Байгууллагын тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар:.....
Хаяг: аймаг /нийслэл/,..... сум /дүүрэг/,
..... баг /хороо/, гудамж
Холбоо барих:..... цахим хаяг, утасны дугаар

7. Онцгойлон заах нөхцөл:.....

8. Дуусах үед нь зөвшөөрөл олгогчид заавал танилцуулж байх үндсэн үе шатны ажлууд:.....

9. Зөвшөөрөл олгогч байгууллагын тусгай тэмдэглэл:

10. Зөвшөөрөл олгосон албан тушаалтны мэдээлэл:.....
байгууллагын нэр, албан тушаал,
овог нэр,..... гарын үсэг, (тамга, тэмдэг)

Төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх,
ашиглалтад оруулах журмын 2 дугаар хавсралт

**ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ**

№	Өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Он, сар, өдөр	Гарын үсэг

Төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх,
ашиглалтад оруулах журмын 3 дугаар хавсралт

**ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫН ЭХЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН
ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

1. Төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг сунгах шалтгаан:
2. Төмөр замын барилгын ажлын төлөв байдал: үе шат,
..... гүйцэтгэсэн ажлын нэр, төрөл;
3. Төмөр замын барилгын ажил гүйцэтгэх хугацаа:
4. Төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг сунгасан ажилтны мэдээлэл: байгууллагын нэр, албан тушаал,
.....овог нэр, / / гарын үсэг, (тамга, тэмдэг)

Төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх,
ашиглалтад оруулах журмын 4 дүгээр хавсралт

**ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Төмөр замын тээврийн тухай хуулийн 23.3-д заасан /шинээр барих, өргөтгөх, шинэчлэх/ барилга байгууламжийг ашиглалтад оруулах Техникийн комиссын бүрэлдэхүүн:

- Комиссын дарга: -Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын нэгжийн дарга.
- Гишүүд: -Салбарын хяналтын байгууллагын төлөөлөл;
-Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл (салбар тус бүр 1-ээс ихгүй);
- Онцгой байдлын ерөнхий газрын төлөөлөл;
-Техник, технологийн Захиалагчийн хяналтын төлөөлөл;
-Инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл (тухай чиглэлийн дагуу ажил хийгдсэн тохиолдолд);
-Зураг төсөл зохиогч байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид);
- Захиалагч байгууллагын төлөөлөл;
-Ашиглалт хариуцсан байгууллагын төлөөлөл;
-Архивын байгууллагын төлөөлөл;

2. Төмөр замын тээврийн тухай хуулийн 11.1.5, 23.5-д заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссын бүрэлдэхүүн:

- Комиссын дарга: - Холбогдох төрийн захиргааны төв байгууллагын асуудал хариуцсан нэгжийн дарга.
- Гишүүд: - Салбарын хяналтын байгууллагын төлөөлөл;
-Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл
-Захиалагч байгууллагын төлөөлөл
-Ашиглагч байгууллагын төлөөлөл
- Зураг төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид);
-Архивын байгууллагын төлөөлөл.

Тайлбар: Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно.

3. Төмөр замын тээврийн тухай хуулийн 32-д заасан /шинээр барих, өргөтгөх, шинэчлэх/ барилга байгууламжийг (салбар зам) ашиглалтад оруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч: - Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл;

- Гишүүд: - Суурь бүтэц эзэмшигч байгууллагын төлөөлөл;
- Захиалагч байгууллагын төлөөлөл;
- Зураг төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид);
- Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;

- Инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл;
- Архивын байгууллагын төлөөлөл;

Тайлбар: Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно.

Төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журмын 5 дугаар хавсралт

ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДҮГНЭЛТ

Дугаар...

20...оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын аймаг, /нийслэл/, сум /дүүрэг/, баг /хороо/-ны нутаг дэвсгэрт баригдсан ангиллын хүчин чадал бүхий зориулалттай барилга байгууламжид сайдын 20 ... оны сарын ... -ны өдрийн дугаар шийдвэрээр байгуулагдсан ... хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комисс 20 ... оны сарын ... -ны өдрөөс эхлэн ... хоногийн хугацаанд ажиллан барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний огноо, дугаар;

2.2. Төмөр замын барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар

2.3. Захиалагч: /Иргэний хувьд/, харьяалал /аль улсын/, овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, регистрийн дугаар,
Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/, баг /хороо/, гудамж /хороолол/, байр /хашаа, хаалга/-ны дугаар, холбоо барих утас, цахим хаяг;

/Хуулийн этгээдийн хувьд/: оноосон нэр, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар,
Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/, баг /хороо/, гудамж /хороолол/, байр /хашаа, хаалга/-ны дугаар, холбоо барих утас, цахим хаяг;

2.4. Төмөр замын барилгын ажлын гүйцэтгэгч:
оноосон нэр , Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар,
..... барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/, баг
/хороо/, гудамж /хороолол/, байр /хашаа, хаалга/-ны
дугаар, холбоо барих утас, цахим хаяг;

2.5. Төмөр замын барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага:
..... оноосон нэр, Улсын бүртгэлийн гэрчилгээний
дугаар, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/ , гудамж
/хороолол/, байр /хашаа, хаалга/-ны дугаар,
..... холбоо барих утас, цахим хаяг;

2.6. Төмөр замын барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага:
..... оноосон нэр, Улсын бүртгэлийн гэрчилгээний
дугаар, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: аймаг /нийслэл/, сум
/дүүрэг/, баг /хороо/, гудамж /хороолол/, байр
/хашаа, хаалга/-ны дугаар, холбоо барих утас, цахим хаяг;

2.7. Төмөр замын барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:
..... оноосон нэр, Улсын бүртгэлийн
гэрчилгээний дугаар, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн
дугаар,
Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/, гудамж /хороолол/,
..... байр /хашаа, хаалга/-ны дугаар, холбоо
барих утас, цахим хаяг;

2.8. Төмөр замын барилга байгууламжийн төлөв байдал:.....

Гурав. Дүгнэлтийн хэсэг

Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах

-Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

-Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэхүү ангиллын хүчин
чадал бүхий зориулалттай төмөр замын барилга байгууламж, түүний

холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

3.2. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а). Төмөр замын барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б). Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Суурь бүтэц эзэмшигч байгууллагад:

а). Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б). Төмөр замын барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в). Төмөр замын барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ... хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. чиглэлийн жилд хүчин чадал бүхий зэрэглэлийн төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга: ()

Нарийн бичгийн дарга: ()

Гишүүд: ()

***Энэ журмын 7 дугаар хавсралтын хамт хүчинтэй.

Төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журмын 6 дугаар хавсралт

ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ТЕХНИКИЙН КОМИССЫН ДҮГНЭЛТ

Дугаар...

20...оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын аймаг, /нийслэл/, сум /дүүрэг/, баг /хороо/-ны нутаг дэвсгэрт баригдсан ангиллын хүчин чадал бүхий зориулалттай барилга байгууламжид сайдын 20 ... оны сарын ... -ны өдрийн дугаар шийдвэрээр байгуулагдсан ... хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комисс 20 ... оны сарын ... -ны өдрөөс эхлэн ... хоногийн хугацаанд ажиллан барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: огноо, дугаар;

2.2. Төмөр замын барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар:

2.3. Захиалагч байгууллага:

Байгууллагын нэр	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Холбоо барих утас	Цахим шуудан

2.4. Төмөр замын барилгын ажлын гүйцэтгэгч байгууллага:

Байгууллагын нэр	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар	Холбоо барих утас	Цахим шуудан

2.5. Төмөр замын барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага:

Байгууллагын нэр	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар	Холбоо барих утас	Цахим шуудан

2.6. Төмөр замын барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага:

Байгууллагын нэр	Улсын бүртгэлийн	Хаяг	Барилгын ажил гүйцэтгэх	Холбоо барих утас	Цахим шуудан

	гэрчилгээний дугаар		тусгай зөвшөөрлийн дугаар		

2.7. Төмөр замын барилга байгууламжийн суурь бүтэц эзэмшигч байгууллага:

Байгууллагын нэр	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар	Холбоо барих утас	Цахим шуудан

2.8. Төмөр замын барилга байгууламжийн төлөв байдал:

- Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг ажиллуулах

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

- Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг ажиллуулахаас татгалзах

-Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

-Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү чиглэлийн хүчин чадал бүхий зориулалттай төмөр замын барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

3.2. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а). улсын комисс ажилласны дараа төмөр замын барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б). Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Суурь бүтэц эзэмшигч байгууллагад даалгах нь:

а). Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б). Төмөр замын барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в). Төмөр замын барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Техникийн комиссын дүгнэлт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын жагсаалт ... хуудас материал, үүрэг даалгаврын биелэлтийн хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материал, зураг төслийн шифр дугаарын жагсаалт -ыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. чиглэлийн жилд хүчин чадал бүхий зэрэглэлийн төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга: ()

Нарийн бичгийн дарга: ()

Гишүүд: ()

***Энэ журмын 7 дугаар хавсралтын хамт хүчинтэй.

Төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журмын 7 дугаар хавсралт

ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВАХ КОМИССЫН ГИШҮҮНИЙ САНАЛЫН ХУУДАС

Барилга байгууламжийн нэр:

Харъяа байгууллага:

Албан тушаал:

Комиссын гишүүний нэр:

Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар	Биелэлт
Шийдвэр:	

Гарын үсэг: /Тамга, тэмдэг/ Гарын үсгийн тайлал / / Огноо:	Гарын үсэг: /Тамга, тэмдэг/ Гарын үсгийн тайлал / / Огноо:
---------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------

Төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журмын 8 дугаар хавсралт

ТӨМӨР ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД БҮРДҮҮЛСЭН БАЙХ ШААРДЛАГАТАЙ БИЧИГ, БАРИМТЫН ЖАГСААЛТ

№	Бүрдүүлэх бичиг, баримт
А. Төмөр зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгоход бүрдүүлэх бичиг, баримт	
1	Гүйцэтгэгч байгууллагын ажил эхлүүлэх зөвшөөрөл хүссэн албан бичиг
2	Гүйцэтгэгч байгууллагын улсын бүртгэлийн болон төмөр зам, замын байгууламжийн барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар
3	Төмөр зам, замын байгууламжийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ
4	Улаан шугам хүлээлцсэн акт
5	Магадлал хийгдсэн тухайн төмөр зам, замын байгууламжийн иж бүрэн зураг төсөл, экспертизийн дүгнэлт
6	Төмөр зам, замын байгууламжийн барилгын угсралтын ажилд техник, технологийн Захиалагчийн хяналт гүйцэтгэх хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ
7	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс газар олгосон шийдвэр, техникийн нөхцөлүүд
8	Байгаль орчинд нөлөөлөх ерөнхий үнэлгээ, шаардлагатай бол байгаль орчин нөлөөлөх байдлыг албажуулсан нарийвчилсан үнэлгээ
9	Архиологи, палеонтологи, угсаатны зүйн судалгааны тайлан /зураг төслийн шатанд хийгдсэн тохиолдолд/
Б. Төмөр зам, замын байгууламжийн барилгын ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрөл олгоход бүрдүүлэх бичиг, баримт	
1	Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэн Гүйцэтгэгчийн албан хүсэлт
2	Ажил зогсоох шийдвэр гаргасан холбогдох эрх бүхий байгууллагын ажил үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн шийдвэр, дүгнэлт
3	Зөрчил, доголдлыг арилгасан тухай баримт, гүйцэтгэсэн ажлын тайлан

Төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журмын 9 дүгээр хавсралт

ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН БАРИМТ БИЧГИЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ЖАГСААЛТ

/Төмөр замын тээврийн тухай хуулийн 23 дах заалтын бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт/

№	Баримт бичгийн жагсаалт
1	Төмөр замын суурь бүтэц барьж байгуулах тухай Улсын Их Хурлаас баталсан тогтоол, шийдвэрийн албан ёсоор баталгаажсан эрх зүйн баримт бичгийн хуулбар
2	Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон Төрийн захиргааны байгууллагын холбогдох шийдвэр эрх зүйн баримт бичиг
3	Бүтээн байгуулалттай холбоотой Улсын Их хурал, Засгийн газар, Төрийн захиргааны байгууллагын холбогдох шийдвэр эрх зүйн баримт бичгийн хуулбарын эмхэтгэл
4	Тухай барилга байгууламжийг барихтай холбоотой тусгай зөвшөөрлийн хуулбар
5	Захиалагч, зөвлөх үйлчилгээ эрхлэгч, ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч аж ахуй нэгжүүдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
6	Бүтээн байгуулалтын ажлын нэгдсэн товч тайлан
7	Улаан шугам хүлээлцсэн акт
8	Барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл (Талбайн улаан дэвтэр)
9	Барилга угслатын явцын ажил шалгуулах хүсэлт
10	Газар эзэмших эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, түүнтэй адилтгах баримт бичиг буюу Засгийн газрын тогтоол, орон нутгийн засаг захиргааны байгууллагын гэрчилгээний хуулбар
11	Гол зам, өртөө зөрлөгийн зам, замын байгууламж, дохиолол холбооны ажлын гүйцэтгэлийн зураг
12	Замын байдал хэмжсэн тайлан (Зам, хэмжигч, сэв шалгах вагоны тайлан)
13	Техник ашиглалтын түвшин тогтоох, чанар байдлын дүгнэлт
14	Зураг төсөл зохиогч байгууллагын нэгдсэн тайлан
15	Барилга байгууламжтай холбоотой өөрчлөлт орсон зураг төсөл
16	Ил, далд ажлын акт (зам, замын байгууламж, гүүр хоолой, дохиолол холбоо, эрчим хүч, барилга байгууламж)
17	Замын паспортын материал (Замын техникийн байдлын тодорхойлолт, дээд бүтцийн материалын тоо ширхэг гэх мэт)
18	Гүүр, хоолойн паспорт (Техникийн үндсэн тодорхойлолт, километрийн байршил, схем зураг)
19	Эрчим хүчний хангамжийн схем зураг, паспорт, холбогдох дүгнэлтүүд
20	Өртөө зөрлөгүүдийн техникийн захирамжийн акт
21	Өртөө зөрлөгүүдийн барилга байгууламж болон техникийн зориулалттай барилга байгууламжийн гүйцэтгэлийн зураг төсөл холбогдох дүгнэлтүүд
22	Онцгой байдлын газраас гаргасан дүгнэлт.
23	Лабораторийн туршилт шинжилгээний дүгнэлт
24	Геодезийн гүйцэтгэлийн байр зүйн зураг, тайлан
25	Инженер геологи судалгааны тайлан
26	Археологийн авран хамгаалах ажлын тайлан
27	Төмөр замын траасын дагуу хийгдсэн ус зүйн судалгааны тайлан

28	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан
29	Засаг даргын газар олгосон захирамж, карьеруудын нөхөн сэргээсэн актууд (Байгаль орчны Улсын байцаагаар баталгаажуулсан)
30	Зөвлөх үйлчилгээ эрхлэгчийн зам, замын байгууламжийн чанар байдлын талаар гаргасан нэгдсэн дүгнэлт
31	Нийт барилга угсралтын хугацаанд Зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс өгсөн зөвлөн, акт, албан шаардлагын эмхэтгэл ба түүний тайлан, тайлбарын хамт
32	Барилга угсралтын хэрэгжилтын явцад салбар яам, салбарын хяналтын газар болон мэргэжлийн хяналтын улсын байцаагч нарын зүгээс барилгын ажлын явцад хийсэн Төрийн хяналт шалгалтын дагуу өгөгдсөн үүрэг даалгавар, албан шаардлагын биелэлтийн тайлан
33	Барилга угсралтын хугацаанд орон нутгийн удирдлагын байгууллагаас хандсан албан тоот, захирамж болон бусад албан баримт бичгүүдийн эмхэтгэл
34	Суурь бүтцийг ашиглагч, операторын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг тогтоон, шийдвэрлэсэн баримт бичгийн хуулбар
35	Техникийн, Улсын комиссын акт, хэрэгжүүлэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийн тайлан
36	Улсын комиссын ажиллах үед салбарын онцлогоос шалтгаалан нэмэлт баримт бичиг